

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

«ХКН-ЫН ТҮҮХИЙН ЛЕКЦ»**Жилин хот. 1981 он. 647 х.****(Шүүмж)**

1981 оны 3-р сард БНХАУ-ын Жилин хотын хэвлэлийн газраас засварлаж, дахин хэвлэсэн «ХКН-ын түүхийн лекц» нь ХКН үүсэн байгуулагдсанаас эхлэн ХКН-ын 9-р их хурлыг хүртэлх намын түүхийн асуудлыг хамарсан 6 бүлэгтэй 20 хэвлэлийн хуудас хэмжээтэй ажээ.

Аугаа их Октябрийн социалист хувьсгалын шууд нөлөөн дор 1919 онд Хятадад империализм, феодализмыг эсэргүүцсэн 5-р сарын 4-ны хөдөлгөөн өрнөсөн билээ. Тэр үед хятад оронд марксизм-ленинизмийг идэвхитэй сурталчилж байсан коммунист Ли Дачжао, Цюй Цюбо нар уг хөдөлгөөний удирдагчид байв.

Хятадын ард түмний хувьсгалч тэмцлийн үндсэн дээр 1921 онд ХКН байгуулагдсан юм. Хятадын интернационалч коммунистууд коминтерний намч, зарчимч байр суурь, түүнээс ХКН-д үзүүлж байсан бүх талын тусламжийг ямагт өндрөөр үнэлж байлаа.

«ХКН-ын түүхийн лекц» зохиогчдыг зарим талаар хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүргэсэн коминтерны болон ЗХУКН-ын баримт бичгүүдэд дэвшүүлсэн хятадын хувьсгалыг стратеги тактик болон хятад дахь хувьсгалт тэмцлийн зарчмын гол асуудал нь ХКН-д үнэлж баршгүй ач холбогдолтой байжээ. Коминтерн болон ЗХУКН-ын баримт бичгүүдэд хятадын хувьсгалын хөдөлгөх хүчин, түүний онцлогууд, хувьсгалын янз бүрийн шатан дахь үндсэн зорилт болон Хятадад хөрөнгөтний ардчилсан хувьсгал социалист хувьсгалд урган орох боломжийн тухай дүгнэлтүүд агуулагдсан байна. Гэвч ХКН-ын түүхийн гол шинж чанар бол марксист-ленинист интернационалч ба жижиг хөрөнгөтний үндсэрхэх урсгал хоёрын хоорондын тэмцэл юм. Хүн амын бүрэлдэхүүнд нь тариачид зонхилсон хагас колонийн орны нөхцөлд, удирдлагынх нь болон гишүүдийнх нь дийлэнхи хэсэгт пролетари бус давхаргаас гаралтай хүмүүс орсон ХКН-ын өсөлтийн нөхцөлд дээрх тэмцэл болж байсан юм. Энэ тэмцэл уг номонд ч ямар нэгэн хэмжээгээр тусгагджээ.

Мао Зэдун болон маоист түүхчид бодит байдлыг гуйвуулан, асуудлын мөн чанарыг бүрхэгдүүлэхийг оролдсоор байна. Ийм учраас тэд Мао Зедуны «зөв шугамын» эсрэг олон тооны «буруу шугам» гэгчийг сэргүүлэн тавьж Цюй Цюбо, Ван Мин нарын олон коммунистуудыг «баруун, зүүний хэлбэрэлд оролцогчид» гэж дайрч давшилжээ.

Өгүүлэн буй номд «Ван Мин тэргүүтэй зүүн оппортунистуудын чиг шугам бол Ан Лисаны оппортунист шугамыг үргэлжлэл болон гарч ирсэн гуравдахь зүүн оппортунист чиг шугам мөн. Ван Мин тэргүүтэй зүүн оппортунизмын чиг шугам нь догматизмыг онцгойлон баримталж байв. 1930-аад оны үед Москвад суралцсан Ван Мин тэргүүтэй «зүүнтний догматистууд эх орондоо эргэж ирснийхээ дараа намын Төв Хорооны удирдах эрхийг булаан авах гэсэн бүлэглэх хөдөлгөөнийг их хэмжээгээр явуулсан юм»¹ гэх мэтээр дурьджээ.

Маоистууд ХКН-ын доторхи жинхэнэ интернационалч хүчийг эсэргүүцэн тэмцэхийн тулд намын ардчилал, сахилга батыг хөсөрдүүлсэн

¹ХКН-ын түүхийн лекц. 162-р тал

явдлыг уг номонд «хувьсгалч чанарын» жинхэнэ илэрхийлэл гэж үзэх ахицгүй оролдлого хийжээ.

ХКН-дахь жинхэнэ интернационалчид В.И.Лениний зохиол бүтээлүүд, коминтерн болон ЗХУКН-ын баримт бичгүүд, тэдгээрт заасан хятадын ард түмний тэмцэлд шууд хамаарах үндэслэлүүдийг үйл ажиллагааныхаа удирдлага болгож байсны үр дүнд 1949 онд Хятадын хувьсгалын ялалтыг хангасан билээ. Гэтэл Бээжингийн удирдагчид ингэж үзэхгүй байгаа нь тодорхой юм. 1981 оны 6-р сард Бээжинд хуралдсан ХКН-ын ТХ-ны VI бүгд хурал «БНХАУ байгуулагдсанаас хойшхи ХКН-ын түүхийн асуудлуудын тухай» тогтоолыг боловсруулан баталсан юм. Уг тогтоолд «өөрийн хүчинд тулгуурлах» номнолын ачаар хятадын хувьсгал ялалтанд хүрсэн² мэтээр бичсэн байна.

Урьд нь Хятадад хэвлэгдэж байсан намын түүхийн бусад номуудын адил «ХКН-ын түүхийн лекц»-д ч «маогийн сургаал, гавьяа» гэгчээ чамлахааргүй оруулжээ. Маогийн бичсэн өгүүлэл, хэлсэн үг, илтгэлийг бүрэн ба бүрэн бус байдлаар намын тухай сургаал мэтээр удиртгал болгон хэвлэжээ. Гэтэл Мао Зэдун үнэн хэрэгтээ марксизм-ленинизм, шинжлэх ухааны социализмыг олигтой судлаагүйгээр барахгүй хятад дахь ажилчны хөдөлгөөнөөс ч хол тасархай байсан юм. Энэ талаар хятадын одоогийн түүхчид тэс өөр шугам баримталж байгаа нь хэн бүхэнд тодорхой билээ. ХКН-ын түүхийн «гол баатар» гэж тэдний өргөмжилдөг нөгөө Мао ХКН-ын хэд, хэдэн хуралд оролцоогүй юм. Жишээлбэл: «Их хурал болох ёстой байсан газрын нэрийг мартсан» учраас ХКН-ын II их хуралд очоогүй гэдгээ тэр өөрөө Америкийн сурвалжлагч Эдгар Сноуд сайрхан ярьсан байдаг. Мао Зэдун өвчтэй байсан учир IV их хуралд оролцбогүй бөгөөд V их хуралд таслах эрхгүй оролцжээ. 1928 онд Москвад болсон ХКН-ын VI их хуралд тэр очоогүй юм. Эл номд ХКН-ын найман удаагийн их хурлын үнэн түүхийг завхруулан бичжээ.

ХКН анхдугаар их хурлаараа социалист хувьсгал хийж пролетарийн диктатурыг байлдан авч, ангигүй коммунист нийгэм байгуулах явдлыг өөрийн гол зорилтоо болгон дэвшүүлжээ. ХКН-ын анхдугаар их хурал коминтернтэй нэгдэх тухай зарчмын шийдвэр гаргасан юм. Гэтэл, энэ номд «Нам анхдугаар их хурлаар намын анхны программ ба намын ажлын бодит төлөвлөгөөний анхны шийдвэрийг баталжээ»³ гэж тэмдэглэх төдийгөөр хязгаарласан нь тэр үед коминтерний тусламжтайгаар элдэв бэрхшээлийг даван туулж хятадын коммунист хөдөлгөөнд улс төрийн зөв бодлого явуулж байсан гол хүч болох тууштай марксистуудыг үгүйсгэсэн хэрэг юм.

1922 оны 7-р сард Шанхайд хуралдсан II их хурал нь ХКН жинхэнэ пролетарийн нам болох эрмэлзлэл төгс байгааг батлан харуулж, намын зохион байгуулалтыг большевик маягаар хийхийг зааж өгчээ. Намын II, III (1923-оны VI сар), IV (1925 оны 1-р сар) их хурлын баримт бичигт, пролетари нар бол намын гол тулгуур, манлай, хувьсгалын тэргүүлэгч хүчин мөн бөгөөд тариачид бол пролетари нарын гол холбоотон мөн, тариачдын идэвхитэй дэмжлэггүйгээр хятадын хувьсгал ялах боломжгүй юм гэж дурьдсан байдаг билээ. Энэ түүхэн баримтыг өнөөгийн маоист түүхчид, «Тунхаг бичгийн гол дутагдал бол ардчилсан хувьсгалд пролетари ангийн удирдах роль зайлшгүй болохыг зааж чадаагүй явдал юм»⁴, Коминтерний шийдвэр ба III их хурлын шийдвэрт, ажилчин ангийн хүч, ролийг хангалтгүй үнэлсний улмаас пролетари нарын удирдах эрхийн тухай, тариачны газрын тухай, хувьсгалт арми байгуулах тухай

⁵ХКН-ын түүхийн лекц. 40-р тал

⁶О. Владимиров, В. Рязанцев Мао Зэдун улс төрийн үйл ажиллагааны намтрын хуудсууд, 1974 он. 20-р тал.

⁷ХКН-ын түүхийн лекц 139-р тал

⁸Мөн тэнд. 139-р тал.

⁹ХКН-ын түүхийн лекц. 350-р тал.

¹⁰Мөн тэнд 349-р тал.

зэрэг асуудалд анхаарал тавьж чадаагүй юм»³ гэх зэргээр бодит үнэнийг гуйвуулан бичжээ.

Коминтерний гүйцэтгэх хорооны төлөөлөгчдийн шууд оролцоотойгоор 1928 оны 6,7 сард Москвад хуралдсан VI их хурал ХКН-ын түүхэнд чухал үе шат болсон юм. Их Хурлын өмнөхөн мөн оны 2-р сард Коминтерний гүйцэтгэх хорооны IX бүгд хурал Хятад дахь хувьсгалт хөдөлгөөний онцлог, одоогийн шатны шинж чанарыг тодорхойлсон «Хятадын асуудлын талаархи тогтоолыг» баталсан бөгөөд түүнд «Хятадын хувьсгалыг зүйл бүрээр дэмжихийг коминтерний гүйцэтгэх хороо өөрийн бүх салбаруудын үүрэг гэж үзэж байна»⁶ хэмээн тэмдэглэжээ.

Энэ тогтоолын нөлөөгөөр ХКН-ын анхны дэлгэрэнгүй мөрийн хөтөлбөр болсон баримт бичгийг боловсруулан гаргасан VI их хурлын тухай уг номонд өгүүлэхдээ: «ХКН-ын VI их хурлын чиг шугам нь үндсэндээ зөв, манай намын түүхэнд дэвшилт үүрэг гүйцэтгэсэн юм»⁷ гэж арга буюу зөвшөөрөн хүлээгээд цааш нь «гэвч, их хурал бас алдаа, дутагдалтай байсан. Дунд ангийн хоёрдмол шинж ба эсэргүү хүчний дотоод зөрчлийг үнэн зөв тодорхойлж чадаагүй. Эдгээр алдаа, дутагдал нь цаашдаа намын доторхи «зүүнтний» бүлгийнхний үзэл санааны үндэс нь болж «зүүнтнийг хөгжин, өргөжихөд түлхэц болсон»⁸ гэж үзсэн нь янз бүрийн үед намын удирдлагад байж, намын дотор марксист-ленинист, интернационалч байр суурийг хамгаалж байсан Ван Мин, зөвлөл орос оронд очиж, октябрийн хувьсгалын туршлагыг биеээрээ шууд судалсан намын нэрт удирдагч Цюй Цюбо нарын зэрэг коммунистуудын үйл ажиллагааг гүтгэн гуйвуулж буйн тод илрэл юм.

1945 оны 4-6-р саруудад Яньаньд хуралдсан ХКН-ын VII их хурал намын дотор маогийнхны хяналтыг бататгаж, маоизмыг намын үзэл суртлын үндэс болгожээ. Уг номд энэ их хурлын тухайд «эвээ нэгтгэсэн ялгуусан их хурал»⁹ «Намын түүхэнд бодит, гүн гүнзгий ач холбогдолтой болсон их хурал», «Мао Зэдуны үзэл санаа бол марксизмыг үндэсний хэлбэртэй болгохын гайхамшигт үлгэр, дууриал, хятадын коммунизм, хятадын марксизм»¹⁰ гэх зэргээр марксизмыг маоизмаар солисон явдлыг зөвтгөн бичжээ.

1956 оны 9-р сард хуралдсан ХКН-ын VIII их хурал БНХАУ-д социалист нийгэм байгуулах бодлогыг боловсруулан бататгаж ХКН нь үйл ажиллагаандаа гагцхүү марксизм-ленинизмыг удирдлага болгох тухай тунхаглажээ. VIII их хурал уг тунхагийг баталсан нь 1945 онд хуралдсан намын VII их хурлаас ХКН-ын үзэл суртлын мөрийн хөтөлбөр болгон дэвшүүлсэн «Хятадчилсан марксизм», «Маогийн үзэл санааны» тухайн үзэл бодлыг таягдан хаясан билээ. Гэтэл энэ номд VIII их хурал хамтын удирдлагын талаар чухалчлан ярилцсан тухай дурьдсан боловч уг хурлаас Маогийн үзэл санааг намын үзэл суртлын үндэс биш гэдгийг заасан тухай юу ч дурьдаагүй байна.

Ийнхүү «ХКН-ын түүхийн лекц»-д түүний их хурлуудын түүхэн ач холбогдлыг үнэн зөв үнэлж огтхон ч чадаагүй явдал уг номыг зохиогчид Маогийн догматик, үндсэрхэг, жижиг хөрөнгөтний байр суурийг шууд баримталж, пролетарийн интернационализмын үзэл санааг дайран давшилж буйг харуулж байна.

Д. БАЯСГАЛАН

⁵ХКН-ын түүхийн лекц. 40-р тал

⁶О. Владимиров, В. Рязанцев Мао Зэдуны улс төрийн үйл ажиллагааны намтрын хуудсууд, 1974 он. 20-р тал.

⁷ХКН-ын түүхийн лекц 139-р тал

⁸Мөн тэнд. 139-р тал.

⁹ХКН-ын түүхийн лекц. 350-р тал.

¹⁰Мөн тэнд 349-р тал.